

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙГ НЭГ
ДЭХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11, 12 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч мажоритар сонгуулийн тогтолцоог дангаар хэрэглэх нь иргэдийн санал гээгдэх, тойргийн ашиг сонирхол улс орны эрх ашгаас өндөрт тавигдах, олон нийтэд танигдсан, хөрөнгө санхүүгийн боломжтой хүмүүст давуу байдал үүсгэх зэрэг сөрөг талыг бий болгож ирсэн. Пропорциональ сонгуулийн тогтолцоог хэрэглэхэд сонгогчдын санал гээгдэх нь бага, парламент дахь нийгмийн бүлгүүдийн төлөөлөл жигд хангагдах, бодлогын намыг төлөвшүүлэх зэрэг давуу талтай гэж үзжээ.

Иймд мажоритар болон пропорциональ аргын давуу талуудыг тусгасан сонгуулийн тогтолцоотой байх зохицуулалтыг тусгаж, сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангана.

1991-1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж батлах үед Улсын Их Хурлын гишүүдийн тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөхөөр тооцоолж, 76 гишүүнтэй байхаар хуульчилсан. Харин өнөөдөр нэг гишүүн дунджаар 44.7 мянган иргэнийг төлөөлөх болсон. Ингэснээр нэг гишүүний төлөөлөх иргэдийн тоо бараг хоёр дахин нэмэгдэж, парламентын төлөөлөх чадамжийг бууруулж байна. Парламентын засаглалтай олон улсад парламент дунджаар 150-аас доошгүй гишүүнтэй байдаг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангахад чиглэдэг байна. Тиймээс иргэдийг төлөөлөх парламентын чадамжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын 76 гишүүнийг мажоритар, 76 гишүүнийг пропорциональ аргаар сонгохоор Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог тодорхой зааж баталгаажуулснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо тогтвортой байх, намууд сонгуульд шударгаар өрсөлдөх, иргэдэд ойлгомжтой байх, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэний сонгох эрхийг баталгаажуулах ач холбогдолтой гэж мөн хууль санаачлагч үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэхтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Т.Доржханд, Ж.Батсуурь, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Б.Пүрэвдорж нар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Сарангэрэл, Г.Ганболд, Ц.Мөнхцэцэг, Ж.Батсуурь, Г.Занданшатар, Т.Доржханд нар улс төрийн намуудын төлөвшил, Улсын Их Хурлын гишүүдийн нөлөөллийн жинг бууруулах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээр нь бодлогын институт болж төлөвших нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн давхарга бүлгүүдийн төлөөллийг хангах, улс төрийг мөнгөний нөлөөллөөс ангижруулах, төрийн бодлого үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, засгийн эрх мэдлийн хяналт-тэнцэл зохистой байх шаардлагатай талаар нэгдсэн байр суурь илэрхийлсэн болно.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн буюу 80 хувийн саналаар дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Н.ЭНХБОЛД